

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023.07.20

Алтай хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго: Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангахад чиглэгдлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй: Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхдээ аймгийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож, бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалыг баримталлаа.

Хяналт-шинжилгээг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс нэгтгэн ирүүлсэн хэрэгжилтэд үндэслэн гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн: Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө нь 6 бүлгийн 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд хагас жилийн байдлаар хэрэгжилтийн явц 65.76 хувьтай байна. Хэрэгжилтийн товчоог танилцуулбал:

Хяналтад авсан арга хэмжээний тоо			92
Үр дүнтэй	(Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрсэн)	100 %	24
Тодорхой үр дүнд хүрсэн	(Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан)	90 %	13
	(Өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа)	70 %	18
Эрчимжүүлэх шаардлагатай	(Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн)	50 %	13
	(Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа)	30 %	19
Үр дүнгүй		0 %	5
Хэрэгжилтийн дундаж хувь			65.76

ДҮГНЭЛТ

Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1.Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 65.76 хувьтай байна.

2.Дараах 5 арга хэмжээний хэрэгжилт “0” хувьтай буюу “үр дүнгүй” байна.

Үүнд:

- Багийн эмчийн унааг /мотоцикл/ ээлж дараатайгаар шинэчлэх;
- Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;
- Жуулчдын зорин ирэх газруудад отоглох цэг байгуулах;
- Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжны хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах;
- Хантайширын гудамжны явган хүний замыг өргөтгөхөд шаардлагатай материал нийлүүлэх;

3.Дараах 19 арга хэмжээний хэрэгжилт “30” хувьтай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Үүнд:

- Эрүүл мэндийн ажилтныг “Түрээсийн орон сууц”-ны хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлэх;
- Цогт сумын Баянтоорой тосгоны эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг үргэлжлүүлэх;
- Тайшир сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх;
- Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлыг үргэлжлүүлэх;
- Боловсролын байгууллагыг техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах;
- Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжин ажиллах;
- “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй Алтай сумын нарны цахилгаан станцыг 300 кВт-аар өргөтгөж, цэнэг хуримтлуур болон удирдлагын төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх;
- Баян-Уул сумын дэд станцыг өргөтгөх;
- Алтай хотод баригдах 25 мВт-ын хүчин чадалтай дулааны станц, дулаан дамжуулах төвийн барих ажлыг үргэлжлүүлэх;
- Дулааны станц, ДДТ-ын барилгын гадна цахилгаан, холбоо дохиолол, ариутгах татуургын шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх;
- “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд Алтай сумыг нэгдсэн ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугамд холбож, цэвэрлэх байгууламжтай болгох ажлыг үргэлжлүүлэх;
- Аймгийн төвийн 10 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг үргэлжлүүлэх;
- Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай тус бүр 1 газрыг сонгон авч менежментийн төлөвлөгөөг орон нутгийн байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулах;

-Дотоодын амрагч, аялагчид ихээр зорин очиж буй Тайшир сумын Завхан гол, Шарга сумын Талын хүрхрээ зэрэг нөлөөлөлд өртөж буй усны сан бүхий газруудад стандартын шаардлагад нийцсэн хогийн сав, эко ариун цэврийн байгууламж хийж байршуулах;

-Хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газрын нөхөн сэргээлтийг хийлгэн хүлээн авах;

-Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг үргэлжлүүлэх;

-Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд сумдад орон сууцны төслийг хэрэгжүүлэх;

-Жаргалан сумд цэцэрлэгт хүрээлэн байгуулах;

-Төгрөг сумд унд ахуйн зориулалттай авто машин нийлүүлэх;

4.Дараах 13 арга хэмжээний хэрэгжилт “50” хувьтай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Үүнд:

- Дэлгэр сумд баригдсан 75 ортой цэцэрлэгийн үлдэгдэл санхүүжилтийг олгож, Цээл, Чандмань сумд тус бүр 75 ортой, Есөнбулаг сумд 320 ортой 6 дугаар цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх

- Төгрөг, Жаргалан, Халиун сумд тус бүр 100 ортой дотуур байрны барилгыг ашиглалтад оруулж, Баян-Уул сумын 160 ортой барилгын ажлыг үргэлжлүүлэх.

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын нийгмийн хариуцлагын хүрээнд нэгдүгээр ээлж Алтай, Жаргалан, Цогт, Төгрөг, Баянтоорой тосгоны сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг дуусгаж, гуравдугаар ээлжид хэрэгжүүлэх Баян-Уул, Бигэр, Бугат, Чандмань сумын цэцэрлэг, сургууль, дотуур байрны нүхэн жорлонг солих ажлын зураг төсөл боловсруулах;

- Ахмадын сувиллын барилгын ажлыг үргэлжлүүлэх;

- Мал амьтны гоц халдварт өвчингүй эрүүл бүс нутгийг хадгалж, малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;

- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ-Хөдөө" төсөл хэрэгжүүлэх;

- Азийн хөгжлийн банкны “Хүнсний ногооны үйлдвэрлэл, усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Жаргалан сумын Цахирын услалтын системийг шинээр барин 300 га талбайг эргэлтэд оруулах;

- “Хүнсний ногооны үйлдвэрлэл, усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Халиун сумын Ёлтонгийн услалтын системийг шинэчлэн засварлах;

- Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих;

- Төгрөг сумын Далан түрүүний хөв засварлах;

- Есөнбулаг сумын цэвэр усны 1.5 км шугам сүлжээний шинэчлэн солих ажлыг үргэлжлүүлэх;

- Бугат, Хөхморьт, Эрдэнэ сумдад бага оврын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх;

- Есөнбулаг сумын Индэрт, Харзат багийн гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын ажлыг үргэлжлүүлэх;

5.Хэлтэс, агентлагаас ирүүлсэн биелэлт нь үр дүнг тайлагнаагүй, арга хэмжээний агуулга, шалгуур үзүүлэлтдээ нийцээгүй, утга найруулгын алдаатай, хэрэгжилтийн хувийг бодитой бус тооцсон байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1.Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан эрхлэх асуудлын хүрээний “үр дүнгүй” болон “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг хангах, бодит гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэж тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэхдээ холбогдох журамд заасан хугацааг мөрдөх;

3.Холбогдох хэлтсүүдээс ирүүлсэн биелэлтийг нэгтгэхдээ судалгаа, баримт нотолгоонд тулгуурласан эсэхэд дүн шинжилгээ хийж ажиллах, нийт хөрөнгийн хэмжээ, төсвийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр хянан нягталж тайлагнах;

4.Шинээр болон үргэлжлүүлэн баригдаж буй барилгын ажил, өргөтгөл, их засварын ажлуудыг зорилтот түвшинд хүргэхэд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

5.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт заасны дагуу “Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулах;

6.Дээрх хуулийн 18.6 дахь хэсэгт заасны дагуу “Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төслийг 10 дугаар сарын 01-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

Хоёр. Нийгмийн бодлогын хэлтэст:

1.Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан эрхлэх асуудлын хүрээний “үр дүнгүй” болон “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг хангах, бодит гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2.Хариуцсан салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд анхаарч, шинээр болон үргэлжлүүлэн баригдах барилгын ажил, их засварын ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

Гурав. Эрүүл мэндийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

1.Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан эрхлэх асуудлын хүрээний “үр дүнгүй” болон “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг хангах, бодит гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2.Хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээний агуулгад нийцүүлэн шалгуур үзүүлэлтийг хангасан, хугацаа, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн мэдээллүүд тодорхой, арга хэмжээний үр дүн, зорилтот түвшний бодит гүйцэтгэлийг тайлагнаж хэвших;

3.“Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төсөлд тусгах саналаа 8 дугаар сарын 20-ны дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

